

Банкуудын зээлийн тайлан


2016 оны 4 дүгээр улирал

Банкуудын нийт зээлийн үлдэгдэл өмнөх улирлаас 0.6 хувиар буюу 71.9 тэрбум төгрөгөөр буурсан бол өмнөх оны мөн үеэс 6.1 хувиар өсч 12.3 их наяд төгрөгт хүрчээ. Үүнээс татан буугдсан¹ банкуудын зээлийг хасч тооцвол нийт үлдэгдэл 12.1 их наяд төгрөг байна.


Харин банкуудаас Монголын Ипотекийн Корпорацид шилжүүлсэн² зээлийн багцыг оруулж тооцвол зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 6.0 хувийн өсөлттэй байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудаар авч үзвэл хэрэглээний, цалингийн болон тэтгэврийн зээл нийт зээлийн үлдэгдлийн 28.5 хувь, үл хөдлөх хөрөнгийн салбар³ 16.0 хувь, худалдааны салбар 14.1 хувь, барилгын салбар 10.8 хувь, боловсруулах үйлдвэрлэл 10.5 хувь, уул уурхайн салбар 6.2 хувь, бусад салбарууд 14.0 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 1. Зээлийн үлдэгдэл



Зураг 3. Зээлийн үлдэгдэл /гол салбараар/



¹ Зоос, Хадгаламж банк.

² МИК-д шилжүүлсэн 2.12 их наяд төгрөгийн зээлийн дүн нь банкны салбарын үзүүлэлтээс хасагдаж, бусад санхүүгийн байгууллагын үзүүлэлтэд тусгагддаг.

³ МИК-д шилжүүлсэн орон сууцны ипотекийн зээлийг хассанаар


Нийт зээлийн үлдэгдлийн 81.0 хувь нь төгрөгийн, 19.0 хувь нь валютаар олгогдсон зээл байна. Хөдөө аж ахуйн зээл, орон сууцны ипотекийн зээл, хэрэглээний зээл төгрөгөөр түлхүү олгогдож байгаа бол мэдээлэл холбоо, санхүү даатгал, боловсролын салбарт валютын зээл давамгайлж байна.

Зээлийн жилийн өсөлт 2014 оны эхнээс саарч, 2015 оны 2 дугаар улирлаас сөрөг үзүүлэлттэй гарч эхлэв. Энэ нь банкууд МИК-т ОСИЗ-ийг багцлан шилжүүлсэнтэй холбоотой байв. Харин 2016 оны 4 дүгээр улиралд нийт зээл өнгөрсөн оны мөн үеэс 12.5 нэгж хувиар өсч, жилийн өсөлт нь 6.1 хувьд (МИК-д шилжүүлсэн багцыг хассанаар) хүрч эерэг үзүүлэлттэй гарлаа. Үл хөдлөх хөрөнгийн салбар болон хэрэглээний зээл өссөн, боловсруулах үйлдвэрлэлийн болон худалдааны салбарын зээл олголт харьцангуй тогтвортой байгаа зэрэг нь нийт зээлийн өсөлт эерэг үзүүлэлттэй гарахад нөлөөлсөн байна. Харин уул уурхай болон барилгын салбарын зээлийн жилийн өөрчлөлт сөрөг үзүүлэлттэй байна.


Тайлант улиралд банкууд нийт 3 их наяд 94.2 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Шинээр олгосон зээл өмнөх улирлаас 9.4 хувь буюу 265.8 тэрбум төгрөгөөр буурсан бол өнгөрсөн оны мөн үеэс 38.1 хувь буюу 854.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Шинээр олгосон зээлийг салбаруудаар авч үзвэл 1 их наяд 432.7 тэрбум төгрөг буюу 46.3 хувийг хэрэглээний зээлд, 580.4 тэрбум


Зураг 4. Зээлийн үлдэгдэл /төгрөг, валютаар/



Зураг 5. Зээлийн жилийн өсөлтийн задаргаа /гол салбараар/



Зураг 6. Олгосон ба төлөгдсөн зээл




төгрөг буюу 18.8 хувийг бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 219.3 тэрбум төгрөг буюу 7.1 хувийг боловсруулах салбарт, 201.8 тэрбум төгрөг буюу 6.5 хувийг барилгын салбарт, 176.3 тэрбум төгрөг буюу 5.7 хувийг орон сууцны ипотекийн зээлд, 160.5 тэрбум төгрөг буюу 5.2 хувийг уул уурхайн салбарт тус тус олгожээ.

Тайлант улиралд олгосон зээлийн 51.0 хувийг 1 жил хүртэлх хугацаатай, 40.8 хувийг 1-5 жилийн хугацаатай, 8.2 хувийг 5 жилээс дээш хугацаатай олгосон бөгөөд, 1 хүртэл жилийн хугацаатай зээлийн хувийн жин өмнөх оны мөн үеэс 6.3 нэгж хувиар нэмэгдсэн бол 1-5 хүртэл жилийн хугацаатай зээлийн хувийн жин 4.2 нэгж хувиар, 5-аас дээш жилийн хугацаатай зээлийн хувийн жин 2.1 нэгж хувиар тус тус буурсан байна.


Тайлант улиралд 2 их наяд 408.0 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдсөн нь өмнөх оны мөн үеэс 49.7 хувь буюу 1 их наяд 131.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн дүн юм. Нийт зээлийн үлдэгдлийн 84.2 хувь нь хугацаандаа байгаа зээл, 7.3 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 8.5 хувь нь чанаргүй зээл байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл өмнөх улирлаас 42.0 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 114.9 тэрбум төгрөгөөр өсч 899.9 тэрбум төгрөгт хүрсэн байна. Чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх улирлаас 67.8 тэрбум төгрөг буюу 6.1 хувиар буурсан бол өмнөх оны мөн үеэс 225.1 тэрбум төгрөг буюу 27.4 хувиар өсч 1 их наяд 47.5 тэрбум төгрөгт хүрчээ. Харин татан буугдсан Зоос, Хадгаламж банкуудын чанаргүй зээлийг хасч тооцвол нийт зээлд эзлэх чанаргүй зээл 7.0 хувь байна.


Зураг 7. Олгосон зээл /салбараар/



Зураг 8. Олгосон зээл /хугацааны ангиллаар/



Зураг 9. Чанаргүй зээлийн хэмжээ ба өөрчлөлт




Гол салбарууд дахь чанаргүй зээлийн хувь хэмжээг /Зоос, Хадгаламж банкуудыг хассанаар/ авч үзвэл уул уурхайн олборлолтын салбарт 18.5 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 11.4 хувь, бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт 13.2 хувь, хөдөө аж ахуйн салбарт 6.6 хувь, барилгын салбарт 6.1 хувь байна. Харин хугацаа хэтэрсэн зээлийн хувьд уул уурхайн салбарт 56.1 хувь, барилгын салбарт 11.9 хувь, боловсруулах салбарт 6.6 хувьтай байна.

Нийт банкны салбарын чанаргүй зээлийн 25.8 хувийг худалдааны салбар, 17.5 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбар, 14.3 хувийг уул уурхайн салбар, 8.9 хувийг барилгын салбар, үлдсэн хувийг бусад салбаруудын чанаргүй зээл бүрдүүлж байна.

Банкууд чанаргүй зээлээс үүдэж гарах алдагдлаас хэр хамгаалагдсан байгаа эсэхийг тодорхойлдог нөөцийн хүрэлцээний харьцаа (provision coverage ratio)-г салбар бүрээр авч үзвэл гол салбаруудаас мэдээлэл холбоо, уул уурхайн салбар, хэрэглээний зээлийн харьцаа хүрэлцээтэй түвшинд байгаа бол тээвэр, худалдаа, санхүү, даатгалын салбар дахь уг харьцаа бага байна.

Хувийн хэвшил, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл банкны салбарын зээлийн 99.2 хувийг бүрдүүлжээ. Хувийн хэвшлийн зээлийн үлдэгдлийн 20.9 хувийг худалдааны салбарт, 19.1 хувийг барилгын салбарт, 18.5 хувийг боловсруулах үйлдвэрийн салбарт, 11.1 хувийг уул уурхайн салбарт, 30.6 хувийг бусад салбарт тус тус олгожээ


Зураг 10. Чанаргүй зээл, хугацаа хэтэрсэн зээл /тухайн салбартаа эзлэх хувиар/



Зураг 11. Нийт зээлд эзлэх эрдэлийн сан ба чанаргүй зээлийн харьцаа



Зураг 12. Хувийн байгууллагын зээл




Иргэдийн зээлийн үлдэгдлийн 51.6 хувийг орон сууцны ипотекийн зээл (МИК-д шилжүүлсэн зээлийг оруулснаар) бүрдүүлж байгаа бол 39.2 хувийг цалингийн зээл, хадгаламж барьцаалсан зээл, картын зээл, тэтгэврийн зээл болон бусад хэрэгцээнд зориулсан зээл, 4.5 хувийг бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 4.6 хувийг бусад салбарт тус тус олгосон байна.


Хувийн байгууллагын зээлийн жилийн өсөлт 3.6 хувьтай байгаа бол иргэдийн зээл 12.9 хувиар буурсан үзүүлэлтэй байна. Өмнөх улирлын зээлийн үлдэгдэлтэй харьцуулахад иргэдийн зээл 8.6 нэгж хувиар өссөн бол хувийн хэвшлийн зээл 3.6 нэгж хувиар буурсан байна. Харин МИК-д шилжүүлсэн зээлийн багцыг оруулж тооцвол иргэдийн зээл өмнөх оноос 10.9 хувиар өссөн байна.

Тухайн салбарт олгосон зээлийн үлдэгдлийг нийт зээлдэгчдийн тоонд харьцуулахад уул уурхайн салбар хамгийн өндөр (3 тэрбум 808 сая ₮) дүнтэй байгаа бол цахилгаан, хийн хангамжийн салбар (576.4 сая ₮), мэдээлэл холбоо (543.4 сая ₮), санхүү даатгалын салбар (497.7 сая ₮) удаалж байна. Харин нийт зээлд өндөр хувь эзэлдэг худалдаа, орон сууцны ипотекийн зээлийн нэгж зээлийн хэмжээ тус бүр 76.6, 49.3 сая төгрөгийн хооронд байгаа бол хэрэглээний зээлийн хувьд хамгийн бага дүнтэй буюу 4.5 сая төгрөг байна.


Зураг 13. Иргэдийн зээл



Зураг 14. Иргэд, хувийн хэвшилд олгосон зээлийн жилийн өсөлт



Зураг 15. Нэгж зээлийн хэмжээ⁴




⁴ Уул уурхайн салбарыг тус дүрслэлд харуулаагүй

Тайлант улиралд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүүг салбараар авч үзвэл, хөдөө аж ахуйн салбар (22.7%), хэрэглээний зээл (20.5%) болон тээврийн салбар (17.4%) нь өндөр хувьтай байгаа бол худалдаа (15.7%), уул уурхайн (15.1%) салбарт олгосон зээлийн хүү харьцангуй бага байна.

Банкуудын тайлант улиралд олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа⁵ 19.7 сар байна.

Зураг 16. Олгосон зээлийн хүү /салбараар/



⁵ Тайлант улиралд олгосон ОСИЗ-ийн жигнэсэн дундаж хугацааг хассанаар

Иргэд, жижиг дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжид олгосон зээл


Тайлант улиралд иргэдийн зээл 5 их наяд 605.0 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаагийн 33.1 хувь буюу 1 их наяд 855.2 тэрбум төгрөг нь ипотекийн, 27.3 хувь буюу 1 их наяд 528.4 тэрбум төгрөг нь цалингийн, 12.4 хувь буюу 697.8 тэрбум төгрөг нь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх, 9.8 хувь буюу 547.4 тэрбум төгрөг нь тэтгэврийн, 5.3 хувь буюу 298.1 тэрбум төгрөг нь хэрэглээний, 12.1 хувь буюу 678.1 тэрбум төгрөг нь бусад зээл байна.

Иргэдийн нийт зээлд эзлэх чанаргүй зээл 3.4 хувь байгаагаас хэрэглээний зээл 3.3 хувь, цалингийн зээл 2.2 хувь, ипотекийн зээл 2.2 хувьтай байна. Тэтгэврийн зээлийн эргэн төлөлт харьцангуй сайн байна.


Иргэдэд олгосон зээлийн дундаж хүү 19.2 хувь байгаа бөгөөд хэрэглээний (21.6%) болон цалингийн (20.7%) зээлийн хүү харьцангуй өндөр байна. Харин иргэдэд олгогдсон зээлийн дундаж хугацааны хувьд орон сууцны ипотекийн зээл 223.0 сар (18.6 жил), цалингийн зээл 35.4 сар (2.9 жил) байгаа бол тэтгэврийн зээлийн хувьд 8.3 сар байна.

Тайлант улиралд жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ) эрхлэх зориулалтаар аж ахуйн нэгж болон иргэдэд нийт 323.6 тэрбум төгрөгийн зээл олгож, тайлант улирлын эцэст нийт 40465 иргэд, 4840 аж ахуйн нэгжүүд 1 их наяд 980.0 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

Зураг 17. Иргэдийн зээл /зориулалтаар/




Зураг 18. Чанаргүй зээлийн хувь /зориулалтаар/



	Зээлийн дундаж хүү /хувь/	Зээлийн дундаж хугацаа /сар/
Иргэдийн зээл	19.2%	44.9
Ипотекийн зээл	9.6%	223.0 (18.6 жил)
Хэрэглээний зээл	21.6%	12.8
Цалингийн зээл	20.7%	35.4 (2.9 жил)
Тэтгэврийн	18.0%	8.3
Бусад зээл	20.5%	11.6


Зураг 19. ЖДҮ-ийн зээлийн хэмжээ /салбараар/



Үүнээс 35.2 хувь буюу 697.8 тэрбум төгрөг нь ЖДҮ эрхлэгч иргэдийн зээл, 64.8 хувь буюу 1 их наяд 282.2 тэрбум төгрөг нь ЖДҮ эрхлэгч аж ахуйн нэгжийн зээл байна. ЖДҮ-ийн зээлийг салбараар авч үзвэл худалдаа (32.8%) болон боловсруулах үйлдвэрлэлийн (21.7%) салбарт түлхүү олгогдсон байна. ЖДҮ-ийн нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь 12.2 хувь байгаа бөгөөд үйлчилгээ, барилга, хөдөө аж ахуйн салбарын ЖДҮ эрхлэгч иргэдэд олгосон зээлийн чанаргүй зээлийн хувь харьцангуй өндөр байгаа бол худалдааны салбараас бусад аж ахуйн нэгжүүдийн чанаргүй зээлийн хувь харьцангуй бага байна.

ЖДҮ эрхлэгчдэд олгож буй зээлийн дундаж хүү болон хугацааг харьцуулахад иргэдэд олгогдож буй зээлийн хүү (23.1%) харьцангуй өндөр, урт хугацаатай (28.6 сар) байгаа бол ААН-ийн зээлийн хүү бага (18.5%), харин дундаж хугацаа нь богино (25.5 сар) байна.

Зураг 20. ЖДҮ-ийн чанаргүй зээлийн хувь



Зураг 21. ЖДҮ-ийн зээлийн хүү, хугацаа

